



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан
тушаалтны жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 20.4 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 146 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 4.1.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны өдрийн А/1205 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм”-ийн 7.1.1, Газрын даргын 2022 оны А/143 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 15.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тагнуулын Ерөнхий газрын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 09/79 дүгээр “Мэдээлэл ирүүлэх тухай” албан бичгийн дагуу Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан жагсаалтад дурдсан албан хаагчдаас нууцын баталгаа гаргуулан авч, аюулгүй байдлын шалгалтад хамруулан, холбогдох бусад арга хэмжээ авч ажиллахыг Нууц хамгаалах ажилтан (Б.Оюун-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЭНХТАЙВАН

☆

10 20



Боловсруулсан: *[Signature]*
Хянасан: *[Signature]*
Хувь: *[Signature]*
Огноо: 2025.01.23.

1120201031

Нийслэлийн Худалдан авах
ажиллагааны газрын даргын 2023
оны 01 дүгээр сарын 23 -ны
өдрийн 4/41 тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ТӨРИЙН НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХ БҮХИЙ
АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

2023 оны 01 дүгээр сарын 23

Улаанбаатар хот

Д/д	Албан тушаал	Төрийн нууцтай танилцах эрхийн түвшин		Үндэслэл, тайлбар
		1 дүгээр түвшин	2 дугаар түвшин	
1.	Газрын дарга	-	+	Нийслэлийн Засаг даргын захирамжаар Төрийн нууцтай холбоотой хөрөнгө оруулалтын ажлыг шуурхай зохион байгуулах эрх шилжиж ирсний дагуу Төрийн нууцтай холбогдолтой баримт бичгийг хүлээн авч танилцах, үүрэг даалгавар өгөх, явц, үр дүнтэй танилцаж, шалгарсан аж ахуй нэгжид гэрээ байгуулах эрх олгох.
Захиргаа, санхүүгийн хэлтэс				
2.	Хэлтсийн дарга	-	+	Нийслэлийн Засаг даргын захирамжаар Төрийн нууцтай холбоотой хөрөнгө оруулалтын ажлыг шуурхай зохион байгуулах эрх шилжиж ирсний дагуу мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, ирүүлсэн албан бичиг цохох, шийдвэрлэх, явуулж буй албан бичиг хянах;
3.	Ахлах нягтлах бодогч	-	+	Төрийн нууцтай холбоотой хөрөнгө оруулалтын ажил зохион байгуулсан тухай төсөв, санхүүтэй холбоотой ажил;
4.	Архивын зааварлагч, арга зүйч	-	+	Төрийн нууцтай холбоотой хөрөнгө оруулалтын ажил зохион байгуулсан баримт бичгийг архивлах, хадгалахтай холбоотойгоор танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх;
Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтэс				
5.	Хэлтсийн дарга	-	+	Нийслэлийн Засаг даргын захирамжаар Төрийн нууцтай холбоотой хөрөнгө оруулалтын ажлыг шуурхай зохион байгуулах эрх шилжиж ирсний дагуу ажлын хэсэгт даргаар орж ажиллах;
6.	Ахлах мэргэжилтэн	-	+	Нийслэлийн Засаг даргын захирамжаар Төрийн нууцтай холбоотой хөрөнгө оруулалтын ажлыг шуурхай зохион байгуулах эрх шилжиж ирсний дагуу Газрын даргын тушаалаар ажлын хэсэгт даргаар, нарийн бичгээр орж ажиллах;
Хууль, эрх зүйн хэлтэс				
7.	Хэлтсийн дарга	-	+	Нийслэлийн Засаг даргын захирамжаар Төрийн нууцтай холбоотой хөрөнгө оруулалтын ажлыг шуурхай зохион байгуулах эрх шилжиж ирсний дагуу хууль зүйн мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, ирүүлсэн албан бичиг цохох, шийдвэрлэх, явуулж буй албан бичиг хянах;
8.	Ахлах мэргэжилтэн (Нууц)	-	+	Нийслэлийн Засаг даргын захирамжаар Төрийн нууцтай холбоотой хөрөнгө оруулалтын ажлыг шуурхай зохион байгуулах эрх шилжиж ирсний

	хамгаалах ажилтан)			дагуу төрийн нууц хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлэх;
Мэдээллийн технологийн хэлтэс				
9.	Хэлтсийн дарга	-	+	Нийслэлийн Засаг даргын захирамжаар Төрийн нууцтай холбоотой хөрөнгө оруулалтын ажлыг шуурхай зохион байгуулах эрх шилжиж ирсний дагуу мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, ажлын хэсэгт орж ажиллах;
10.	Мэдээллийн технологи хариуцсан ахлах мэргэжилтэн	-	+	Нийслэлийн Засаг даргын захирамжаар Төрийн нууцтай холбоотой хөрөнгө оруулалтын ажлыг шуурхай зохион байгуулах эрх шилжиж ирсний дагуу мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, тайлан, мэдээний системд шивж, тайлагнах.

--oOo--